

ЭРҮҮЛ МЭНДИЙН, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2013 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 159/189

Улаанбаатар хот

Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 8.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 22 дугаар зүйлийн 22.1.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 24 дүгээр зүйлийн 24.3 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журам-ыг” нэгдүгээр, “Гадаадаас Монгол улсад ажиллаж буй иргэдийн эрүүл мэндийн үзлэгийн маягт”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн захирал нарт үүрэг болгосугай.

Гурав. Тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар), Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Б.Ганцэцэг)-т даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ



САЙД

Я.САНЖМЯТАВ





Эрүүл мэндийн, Хөдөлмөрийн сайдын
хамтарсан 2019 оны 12/13 Тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд хамруулах (цаашид гадаадын иргэн гэх) үйл ажиллагааг зохион байгуулах, мэдээлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтэнд ХДХВ/ДОХ, тэмбүү, элэгний В,С вирусын халдвар илрүүлэх болон уушигны сүрьеэгийн үзлэг, шинжилгээг хийж үзлэгийн нэгдсэн тайланг холбогдох журмын дагуу гаргана.

1.3. ХДХВ-ийн халдварын тохиолдлын мэдээлэл нь холбогдох хууль, тогтоомж, журмаар зохицуулагдана.

Хоёр: Үзлэг зохион байгуулах, мэдээлэх

а) Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв нь:

2.1. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдах гадаадын иргэдийн нэрс, гадаад паспортын дугаарын жагсаалт, ажиллах газар нутгийн байршлын хамт Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвд үзлэг эхлэхээс 10 хоногийн өмнө албаны цахим хаягаар хүргүүлэх ба албан бичгээр мөн давхар хүргүүлж баталгаажуулсан байна.

2.2. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр энэ журамд заасан өвчин илэрч, эрүүл мэндээр тэнцээгүй иргэний асуудлыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт холбогдох мэдээллийн хамт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

2.3. Эрүүл мэндийн үзлэгийн талаархи мэдээллийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

б) Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв нь:

2.4. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс ирүүлсэн гадаадын иргэдийн нэрс, гадаад паспортын дугаар, ажиллах газар нутгийн байршлын жагсаалтыг орон нутгийн Эрүүл мэндийн газарт 3 хоногийн дотор албаны цахим хаягаар хүргүүлэх ба албан бичгээр мөн давхар хүргүүлж баталгаажуулсан байна.

2.5. Эрүүл мэндээр тэнцээгүй гадаадын иргэний мэдээллийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас тайлан ирүүлснээс хойш 2 хоногт багтаан Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд албан бичгээр хүргүүлнэ.

2.6. Орон нутгийн эрүүл мэндийн газраас гадаадын иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан талаархи тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд тухай бүрт, Эрүүл мэндийн яаманд хагас жил тутамд ирүүлнэ.

в) Орон нутаг дахь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллага нь:

2.7. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн жагсаалтын дагуу энэ журамд заасан 5 төрлийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийг оруулна.

2.8. Гадаадын иргэдийг үзлэг шинжилгээнд оруулахдаа халдвар үзлэг шинжилгээний байршлыг харилцан тохиролцож, халдвар хамгааллын болон бусад дүрэм, журмыг баримтлан, аж ахуйн нэгжид аль болох хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулна.

2.9. Үзлэг шинжилгээний хариуг энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягт дээр гаргаж, гарын үсэг зуран тамга дарж баталгаажуулна.

2.10. Шинжилгээг мэдрэг, өвөрмөц чанар өндөртэй оношлуураар хийж, шинжилгээний хариу эргэлзээтэй тохиолдолд дараагийн шатлалд холбогдох журмын дагуу илгээж, хариуг баталгаажуулна.

2.11. Эрүүл мэндээр тэнцсэн иргэдийг эрүүл мэндийн давтан үзлэг шинжилгээнд жил бүр, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд 6 сар тутамд оруулна.

2.12. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүнг үзлэг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд тэнцсэн, тэнцээгүй гэсэн үзүүлэлтээр гаргаж хүргүүлнэ.

2.13. Эрүүл мэндийн үзлэгтэй холбоотой бичиг баримтыг Архивын тухай хуулийн дагуу хадгална.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр

3.1. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын нэг иргэний эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд шаардагдах зардлын хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жишиг үнийг мөрдлөг болгоно.

3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд шаардагдах төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.



121

Эрүүл мэнд, Хөдөлмөрийн сайдын
хамтарсан ажлын оны 159/189 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

**Гадаадаас Монгол улсад ажиллаж буй иргэдийн
эрүүл мэндийн үзлэгийн маягт**

- A. Урьдчилсан үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллагын нэр
- B. Гадаадаас ажиллах хүч авч буй байгууллагын нэр
- B. Иргэний овог..... нэр:..... Нас..... Хүйс.....
- Г. Иргэний харъяалал.....
- Д. Паспортын дугаар
- Е. Шинжилгээний дүн:

№	Үзүүлэлт	Хариу
1	HIV	
2	Сүрьеэ	
3	TPHA	
4	HBs антиген	
5	HCV	
	Дүгнэлт	

Эмчилгээ эрхэлсэн захирал :

Тамга Эмч:

Лабораторийн эмч:

Лаборант:

.....он.....сар.....өдөр